

АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ГЭРЭЭ

2014 оны 6 дугаар
сарын 17-ны өдөр

дугаар АӨҮА-2014/19 77

Улаанбаатар
хот

Ерөнхий зүйл

Ашигт малтмалын тухай хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас Ашигт Малтмалын Газар (цаашид АМГ гэнэ), нөгөө талаас XV-008582 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч Улаанбаатар хотын Үндэсний татварын ерөнхий газарт бүртгэлтэй, аж ахуйн нэгжийн 9011073001 тоот гэрчилгээ, 5057035 регистрийн дугаартай “Тэнгэрийн гэгээн тал” ХХК (цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигч гэнэ) нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 078 тоот тушаалаар батлагдсан Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журмыг үндэслэн Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт орших Шарга-Овоогийн алтны үндсэн ордын /Шарга-Овоо-1 хэсэгт/ ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үед хийгдэх үндсэн ажлуудын хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх үе шат, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний нөхцөл, хугацаа

1. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
 - a. Орд ашиглах зураг төсөл боловсруулах;
 - b. Ордын нөөцөд тулгуурлан ТЭЗҮ боловсруулах;
 - c. Уурхай барьж байгуулах;
2. Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг 2016 оны 8 дугаар сарын 25-ны дотор хийх.
3. Ордын технологийн туршилтын хугацаа 1 жил байна.
4. Орд ашиглах төслийн хүчин чадалд хүрэх хугацаа 2,4 жил байна.
5. Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт орших Шарга-Овоогийн алтны үндсэн ордын /Шарга-Овоо-1 хэсэгт/ ашиглалтын өмнөх үйл ажиллагааг 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдөр дуусгавар болгоно.

Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын зардлыг улсын төсөвт нөхөн төлөх гэрээг орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахаас өмнө Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу байгуулсан байна.
2. Ашигт малтмалын тухай хуулийн 48-д заасныг үндэслэн АМГ-ын даргын 2009 оны 411 дүгээр тушаалаар батлагдсан АМГ-ын ГСХ-ийн “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд гүйцэтгэсэн хайгуулын ажлын жилийн тайлан хүлээн авах, хайгуулын ажлын зардлын доод хэмжээг тооцох” дотоод зааврын дагуу жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор хайгуулын ажлын тайланг ГСХ-т хүргүүлж хайгуулын ажлын доод

111

хэмжээг баталгаажуулж, хуулбарыг гэрээний биелэлтийн тайлангийн хамт гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш (1) жил тутам УУСХ-т ирүүлнэ.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний биелэлттэй холбоотойгоор АМГ-аас үзлэг, шалгалт хийж байгаа төлөөлөгчдөд холбогдох баримт, бичгүүдтэй танилцах боломж олгон, үйлдвэрлэлийн талбайд саадгүй нэвтрүүлнэ.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтээ АМГ-т бичгээр гаргаж болно.

5. Орд ашиглахтай холбогдсон баримт бичгийг Монгол хэл дээр үйлдсэн байна.

6. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд гарч байгаа зардлуудыг татварын албанд тушаасан тухай мэдэгдлийг тайланд тусгасан байна.

7. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үед хайгуул судалгааны ажил хийгээгүй талбайг Ашигт малтмалын тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу буцааж өгөх.

8. Энэхүү гэрээг гэрээнд заасан нөхцөлөөс өөр хэлбэрээр ашиглахыг хориглоно.

Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын эрх, үүрэг

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний биелэлтийн талаар болон ашиглалтын өмнөх үйл ажиллагааны явцын тухай мэдээлэл авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ тухай хүсэлтийг бичгээр хүргүүлнэ.

2. Энэхүү гэрээний заалтуудад өөрчлөлт оруулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авсан байна.

3. Гэрээний заалтуудын биелэлтэд үзлэг, шалгалт хийх хүсэлтээ бичгээр хүргүүлнэ.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариуг бичгээр хүргүүлнэ.

5. Энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг бичгээр авсан байна.

Дөрөвдүгээр зүйл. Бусад зүйл.

1. Энэхүү гэрээнд АМГ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү гэрээний биелэлтийг ордыг ашиглалтад хүлээн авсан комиссын дүгнэлт, шийдвэр (гэрээний заалтууд бүрэн биелсэн акт)-ийг үндэслэн гэрээлэгч талууд хамтран дүгнэж акт үйлдэнэ.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гарах үр дагаврыг бүрэн хариуцна.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний биелэлтийг АМГ-тай хамтран дүгнээгүй тохиолдолд ашигт малтмалын XV-008582 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

5. Гэрээг 3 /гурав/ хувь үйлдсэн бөгөөд 1 /нэг/ хувийг АМГ-ын Уул уурхайн асуудал хариуцсан нэгжид, 1 /нэг/ хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, 1 /нэг/ хувийг кадастрын бүртгэлийн төвийн архивт тус тус хадгална.


6. Энэхүү гэрээний биелэлттэй холбогдон гарах маргааныг гэрээлэгч талууд харилцан тохирч шийдэх бөгөөд эс шийдэлд хүрсэн тохиолдолд Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ашигт малтмалын газрыг төлөөлж:
Уул уурхайн хэлтсийн
дарга.....С.Баттулга



Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:
“Тэнгэрийн гэгээн тал” ХХК-ийн захирал
Э.Очмаа..... Э.Очмаа



Handwritten signature

АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн бүртгэл хийгдэж байгаатай холбогдуулан нэг талаас Ашигт малтмалын газар /цаашид АМГ гэх/, нөгөө талаас Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт орших Шарга- Овоогийн /Шарга-Овоо-1 хэсэг/ алтны үндсэн ордын XV-008582 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Тэнгэрийн гэгээн тал” ХХК-тай байгуулсан № АӨҮАГ-2014/19/77 тоот гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулав.

Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсан хавсралт нь үндсэн (№АӨҮАГ-2014/19/77) тоот гэрээний салшгүй хэсэг байна.

1. Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт орших Шарга-Овоогийн алтны үндсэн шороон ордын талбайн ашигт малтмалын хайгуулын XV-008582 тоот тусгай зөвшөөрлийн хугацаа 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдөр дуусгавар болно.
2. Тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг үндсэн гэрээ байгуулах үед мөрдөж байсан хуулийн дагуу төлөх буюу төлбөрийн хэмжээ 1 гектар тутамд 1.5 америк доллар байна.
3. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай гэрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтийг мөрдөж ажиллана.
4. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээнд оруулах энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө баталгаажуулж, тусгай зөвшөөрлийн хавсралтанд шинэчлэн бүртгүүлсэн тухай тэмдэглэгээ хийлгэнэ.

Ашигт малтмалын газрыг төлөөлж:
Уул уурхайн хэлтсийн дарга
..... С.Баттулга



Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:
“Тэнгэрийн гэгээн тал” ХХК-ийн захирал
..... Э.Очмаа..... Э.Очмаа



Handwritten signature

АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ
ДҮГНЭСЭН ТУХАЙ АКТ №2016/17

2016.09.05

Нэг талаас Ашигт малтмалын газар, нөгөө талаас Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт орших Шарга – Овоогийн алтны үндсэн ордын XV-008582, ХҮ-008020 тоот хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг эзэмшигч “Тэнгэрийн гэгээн тал” ХХК нар харилцан тохиролцож байгуулсан 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн №АӨҮА-2014/19/77, 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн №АӨҮА-2014/14/37 тоот гэрээнүүдийн биелэлтийг хамтран дүгнэвэл:

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутаг дахь Шарга-Овоогийн алтны үндсэн орд /Шарга-Овоо-1, Тэмээт толгойн хэсэг буюу 3-р хүдрийн биетийн талбай/ -ыг ашиглах Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр “Хөтөч од” ХХК-ийн захирал Д.Гансүхтэй 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдөр гэрээ байгуулан ажиллаж байна.

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт орших ХҮ-008020, ХҮ-008582 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас 2016.07.05-ны өдрийн 11/4243 тоотоор “Тэнгэрийн гэгээн тал” ХХК-д хүргүүлсэн байна.

Иймд Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.1-д заасны дагуу тусгай зөвшөөрөл авсны дараа Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах боломжтой гэж үзэн гэрээний үүргээ биелүүлсэн талаарх баримт бичгийг үндэслэн гэрээг хамтран дүгнэв.

АМГТГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ:

УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ХАНГАЙ

УХА0585
532353 1116 128255



“ТЭНГЭРИЙН ГЭГЭЭН ТАЛ” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

ТЭНГЭРИЙН
ГЭГЭЭН ТАЛ
ХХК
ЗАХИРАЛ Э.Очмаа Э.ОЧМАА